МЭДЭЭ · 2022 оны 9-р сарын 7

ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД ХОХИРСОН, ХОЛБОГДСОН ХЭРЭГТ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛӨӨЛӨГЧӨӨР ТОГТООГДСОН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД СУРГАЛТ ХИЙЛЭЭ



Төв аймгийн прокурорын газраас тус аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран өсвөр насны хүүхэд хохирсон, холбогдсон хэрэгт хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдсон мэргэжилтнүүдэд сургалт зохион байгууллаа.

Сургалтад Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын болон 27 сумдын Засаг даргын Тамгын газрын нийгмийн бодлогын 40 мэргэжилтэн оролцож, хууль ёсны төлөөлөгчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, анхаарах асуудлын талаар хууль эрх зүйн ойлголт мэдээллийг авсан байна.